МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

ЗАЛУУЧУУД БА УР ЧАДВАР ОЛГОХ БОЛОВСРОЛ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

ЦУВРАЛ №7

2018 ОНЫ 3 САР

“Таны нэмж эзэмшсэн ур чадвар бүр таны амжилтыг хоёр дахин өсгөнө.”
Скотт Адамс

ОРШИЛ

Өнөөдөр дэлхий дээрх 15-аас 24 насны нэг тэрбум гаруй залуучууд урд өмнө байгаагүй хамгийн их мэдээлэлтэй, идэвхтэй, өөр хоорондоо холбоотой, хөдөлгөөнтэй шинэ үеийнхэн болж байна. Дэлхий дээрх 15-аас 24 насны залуучуудын 90 гаруй хувь нь Facebook, Twitter зэрэг сошиал сүлжээний ямар нэг хэлбэрт нэгдсэн байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тооцоогоор 2017 онд дэлхий дээр 71 сая залуучууд ажилгүй байна.

2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын үр дагавар нь залуучуудын дунд ажилгүйдэл өсөхөд хүргэжээ. Эдийн засгийн даяаршил эрчимжиж байгаа нь боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний хоорондын зөрүүг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг бууруулж, залуучуудын дунд ажилгүйдэл болон тогтвортой биш ажил эрхлэлтийг өсгөх хандлагыг бий болгож байна. Хөдөлмөр эрхлэлт буурч байгаа хандлага нь шинэ үеийн залуучууд хөдөлмөрийн зах зээлд оройтож орох, эсвэл огт орж чадахгүй байгаатай холбоотой. Үүнээс болж залуучуудын урам зориг улам хугарах явдал ажиглагдах болж байна. Залуучуудын ажилгүйдэл бол нэг талаас, боловсролын салбарын нийлүүлэлт, мэргэжлийн бэлтгэл, нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагын шүтэлцээ алдагдсаныг харуулахын зэрэгцээ эдийн засгийн бодлогын хүрээнд гаргасан шийдвэрүүд, эрх баригчдын улс төрийн хариуцлагатай шууд холбоотой юм. Үүний зэрэгцээ залуучууд боловсролоос ажил хөдөлмөрийн салбар руу шилжих үед явагдаж байгаа үйл явц, дүр зургийг анхааралтай судалж, сайтар ойлгох хэрэгтэй байна. Энэ шилжилтийн үе удаашралтай явагдаж байгаа нь боловсролоор олж авсан ур чадвар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ хоёрын хоорондын уялдаа шүтэлцээний зөрүүтэй байдалтай холбоотойгоос гадна бусад олон шалтгаан байна. Хэдийгээр эдийн засгийн талаас шилжилтийн энэ үе үр ашиггүй байж болох ч, зарим залуучуудын хувьд энэ нь олон нийтийн болон сайн дурын хөдөлгөөнд оролцох, аялалд явах, чөлөөт цагаараа урлаг болон бусад үйл ажиллагаанд оролцох замаар сурах чухал үе болж өгдөг. Түүнээс гадна боловсролтой залуучууд ажилгүй байсан ч иргэний, нийгмийн, улс төрийн үйл ажиллагааны тэргүүн эгнээнд орж ирж болох юм.

Нөгөө талаас, залуучууд, ажилчдын боловсролын түвшин байнга өсөж байгаа явдал ажлын байрны төлөөх өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна. Албан ёсны боловсрол олж авч байгаа залуучуудын дийлэнх хэсэг нь дипломтай болсноор ажил хялбар олж авах, ирээдүйдээ илүү итгэлтэй байх зэрэг давуу талаа ашиглаж, түүний ач тусыг хүртэж чадахгүйд хүрч байна. Зарим улс орны хувьд нийгмийн байр сууриа ахиулах, сайн сайхан аж амьдралын бодит хүчин зүйл нь боловсрол гэдэгт итгэх итгэл алдрах явдал нэмэгдэж байна. 1990-ээд оноос хойш боловсролын хүртээмж эрс нэмэгдсэнтэй уялдан нийгэм дотор өсөн дэвших талаарх итгэл найдвар дэлхийн олон оронд унтарч эхэлсэн байна. Ирээдүйд “илүү дээгүүр байр суурь”-т хүргэх гол түлхүүр бол боловсрол гэж үздэг уламжлалт ойлголтоос татгалзаж, түүнд оруулсан “хөрөнгө оруулалтын өгөөж”-ийн тухай асуулт тавих болж байна. Манай орны хувьд ч залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудал шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болж байгаа учраас бодлогын цуврал зөвлөмжийн энэ дугаарыг ур чадварын боловсролд зориулж байна.

ТЕХНИК МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН НИЙГЭМД ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Өнөөдрийг хүртэл техник мэргэжлийн боловсрол нь зах зээлд мэргэжилтэй ажилчид бэлтгэн нийлүүлэх зорилгоор төлөвлөгдөж явж ирсэн. Тэгвэл орчин үед техник мэргэжлийн боловсрол нь эдийн засгийн хөгжлийн хэм аясаар хөтлөгдсөн, улмаар хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангахад чиглэсэн уян хатан байдалд шилжих шаардлага тулгарч байна. Үүний тулд, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг зөв

1

The New York Times.

NEW YORK, WEDNESDAY, AUGUST 3, 1966.

Нью Йорк таймс сонинд долоо хоногт нийтэлж буй мэдээлэл нь 18 дугаар зуунд амьдарч байсан хүний насан туршдаа олох мэдээллээс илүү хэмээн үзжээ.

2

Шинэ техникийн мэдлэг, мэдээлэл 2 жил тутам 2 дахин нэмэгдэж байна. Энэ нь 4 жилийн техникийн сургуулийн оюутны анхны жилд сурсан мэдлэгийн тал нь 3 дахь жилдээ хоцрогдсон байна гэсэн үг юм.

3

10 жилийн өмнө байгаагүй 10 ажлын байр



Австралийн оюутнуудын 60 хувь нь ирээдүйд алга болох буюу автомат роботоор хийгдэх ажлын байранд бэлтгэгдэж байна.

2015. Рачел Браун

Дэлхий дээр байгаа ажлын байнрны 50 орчим хувь буюу 2 сая ажлын байр 2030 он гэхэд алга болно.

2016. Томас Фрей

тодорхойлох, дутагдаж байгаа ур чадварыг бий болгох, залуучуудын ажил хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, тусгай ур чадварын зэрэгцээ цогц чадамжийг олгох, хөдөө орон нутагт шаардлагатай ур чадварын хэрэгцээг хангах талаар төрийн бодлогыг хэрэгжүүлж, шаардлагатай арга хэмжээг авах хэрэгтэй. Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг зөв тодорхойлохын тулд улс орны хөгжлийн үзэл баримтлал, зах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, технологийн шинэчлэл зэргийг сайтар судлах хэрэгтэй. Филлипин, Чили, Голланд зэрэг улс орнууд ийм судалгааны үр дүнд чадамжид тулгуурласан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж байгаа нь үр дүнтэй болох нь батлагдсан байна. Зах зээлд дутагдаж байгаа ур чадварыг бий болгох талаар Камбож, Тунис зэрэг улсад мэдээллийн систем бий болгож, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээний талаар бүрэн мэдээллээр хангаж, сонирхсон хүмүүсийг ярилцлагад урьж оролцуулдаг бол Итали улсад дутагдаж байгаа ур чадварыг олгох сургалтанд сонирхсон хүмүүсийг урьж оролцуулан шалгаруулан авч хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангаж байна. Залуучуудын ажил хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх талаар тэдэнд нарийн мэргэшлийн ур чадвар олгохын зэрэгцээ хүнтэй харьцах чадвар, хэлний мэдлэг, нийгмийн идэвхи, бүтээлч сэтгэлгээ зэрэг “зөөлөн” ур чадвар олгоход түлхүү анхаарч тэднийг хөдөлмөрийн зах зээлд гарахад нь бэлтгэж байна. Турк улс оюутнуудад бизнес эрхлэх анхан шатны мэдлэг олгож, ажил хэрэгч хүн болоход нь тусалж байхад Англи, Австрали улсад уламжлалт бус мэргэжлээр тухайлбал, гар урлалын чиглэлээр дагалдан сургах аргыг өргөн ашиглаж байна. Хөдөө орон нутагт шаардлагатай ур чадварын хэрэгцээг хангахын тулд орон нутагт сургалтын төвүүдийг байгуулж, ажилгүй эмзэг бүлгийн хүмүүсийг мэдээллээр хангаж, тодорхой ур чадвар олгож, амьдралын түвшнээ дээшлүүлэх бололцоо олгож байна. Энэтхэг улс бүр Политехникийн сургалт явуулдаг төвүүдийг байгуулж ажиллуулснаар орон нутгийн хөгжлийг сэргээж чадсан байна. Бразил улсад Хөдөө аж ахуйн холбоог төрийн сургуультай холбож, хөдөө орон нутагт шаардлагатай ур чадвар олгох сургалтыг явуулж эхэлсэн нь хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнийг бууруулж, орон нутагтаа тогтвортой ажиллах нөхцлийг бий болгож орон нутгийн хөгжилд дорвитой нөлөө үзүүлсэн байна. Улс орны эдийн засгийн хөгжилд тусгай ур чадварын зэрэгцээ цогц чадамж эзэмшсэн хүмүүс чухал үүрэг гүйцэтгэх болж байна. Япон, Малайз, Тайланд зэрэг улс оронд нарийн мэргэшлийн ур чадвараас гадна “хөрвөх чадвартай зөөлөн” ур чадварыг мэргэшлийн тодорхойлолт, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрт оруулж өгсөн байна.

ТЕХНИК, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СИСТЕМИЙН ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

Эдийн засгийн өсөлт, улс орны тогтвортой хөгжил, нийгмийн эрх тэгш байдлыг хангахад мэргэжилтэй ажилчид бэлтгэх системийг бэхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүний тулд, техник мэргэжлийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, ажлын байранд ур чадвар олгох сургалтыг өргөжүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэх, багш нарыг нарийн мэргэжлээр мэргэшүүлэх, техник мэргэжлийн сургуулийн удирдлагыг бэхжүүлэх зэрэг олон талт арга хэмжээ авч явуулж байгаа нь улс орнуудын туршлагаас харагдаж байна. Техник мэргэжлийн боловсролд хамрагчдын тоо сүүлийн хориод жил дэлхий дахинаа буурсан дүр зураг харагдаж байна. Юуны өмнө, техник мэргэжлийн сургуульд сурлагаар хоцрогчид сурдаг, ийм сургууль төгсснөөр цаашид сурах ирээдүй хаагдана гэсэн ойлголт дэлхийн олон оронд байдаг учир энэ төрлийн сургуулийг сонгох залуусын тоо буурсаар байна. Өөрөөр хэлбэл, техник мэргэжлийн сургууль нь боловсролын бусад түвшнээс салангид тусгаар байдалтай байдаг. Ийм учраас зарим улс орнууд дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт мэргэшил олгох сургалтыг оруулж өгсөн байна. Тухайлбал, Францад baccalaureat professionel, Голландад middle-baar beroepsonderwijs хөтөлбөрийг хэрэгжүүлж байхад, Өмнөд Солонгост дунд сургуулийн сурагчдын 40% -нь техник мэргэжлийн сургуульд элссэн байна. Түүнээс гадна техник мэргэжлийн сургууль төгсөгчид цаашлаад дээд сургуульд орох замыг нээх зорилгоор Японд эмэгтэйчүүдийн 2 жилийн коллежийг 4 жил болгон өргөтсөн бол АНУ-д нарийн мэргэжил эзэмшүүлэх, ур чадвар олгох зорилго бүхий 2 жилийн коллежийг байгуулж, Өмнөд Солонгост 2-3 жилийн сургалттай мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, төгсөгчдөд цаашлаад дээд сургуульд үргэлжлүүлэн сурах боломжийг нээж өгсөн байна. Түүнээс гадна хувийн өмчид тулгуурласан ур чадвар олгох сургуулиудыг Ойрхи Дорнод, Африкийн улс орнуудад байгуулах хандлага дэлгэрч байна. Ажлын байранд ур чадвар олгох сургалт нь үйлдвэр дээр явагддаг учраас олон янзын аргаар зохион байгуулдаг байна. Албан ёсны гэрээний дагуу үйлдвэр дээр дагалдан сургах, сургууль ажлын хооронд явж, сэндвич байдлаар сургалтанд хамрагдах, үнэ төлбөргүй ажлын байранд ажиллаж дадлага эзэмших, "хоёрдахь боломж" олгох сургалт явуулах зэрэг олон хэлбэр байна. Энд Германы дуал систем өнөө хүртэл анхаарал татаж байна. Ер нь ажлын байранд сургалт явуулах асуудлыг улс төрчид, бизнес эрхлэгчид илүүтэй дэмжих хандлага бий. Учир нь ийм сургалт залуучуудыг амьдралд сургахад дэмждэг, эдийн засгийн болон зах зээлийн хувьд ашигтай, сургах арга зүйг улам боловсронгуй болгодог, техник мэргэжлийн боловсролын өртгийг бууруулдаг ач холбогдолтой. Техник мэргэжлийн боловсролын чанарын асуудалд олон түмэн их шүүмжлэлтэй ханддаг. Ийм учраас сургалтын чанарыг дээшлүүлэх асуудал хурцаар тавигдаж байна. Сургалтын чанарыг дээшлүүлэх талаар мэргэшлийн ангилал, зэрэглэлийг эргэн харж, орчин үеийн шаардлагад тохируулан шинэчлэх нь ур чадварын түвшинг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажиллах хүчний хөрвөх, шилжих чадавхийг сайжруулж, улмаар эдийн засгийн өсөлтөд нөлөөлдөг байна. Цаашилбал, мэргэшлийн шинэ зэрэглэлийн дагуу сургалтын төлөвлөгөөг өөрчлөх, сургалтын ур дүнг хүлээн зөвшөөрөх, батламжлах боломж бүрдэнэ. Австрали, Египет, Өмнөд Солонгос, Румын, Турк зэрэг орнууд чанарын баталгаажуулалтад ихээхэн анхаарал тавьж, тодорхой арга хэмжээ авч байна. Өөр нэг асуудал бол багш нарыг нарийн мэргэжлээр мэргэшүүлэх асуудал юм. Сүүлийн үед техник мэргэжлийн багш нарын цогц чадамжийн хүрээг тодорхойлж тогтоох талаар олон орон онцгой анхаарч ажиллаж байна. Тухайлбал, Филиппинд 2006 онд үндэсний хэмжээнд техник мэргэжлийн сургуулийн багш нарын ур чадвар, мэргэшлийн хөтөлбөр гаргаж, бүх багш нар шаардлагатай цогц чадамж, сургах арга зүй эзэмшсэн эсэхийг тодорхойлж баталгаажуулах ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Европт мэргэшлийн боловсролыг хөгжүүлэх зорилгоор 1975 онд байгуулагдсан CEDEFOR төвөөс мэргэшлийн боловсролын багш ажилтнуудын цогц чадамжийн хүрээг боловсруулж, хэрэгжүүлж байна. Түүнээс гадна техник мэргэжлийн боловсролын багш бэлтгэдэг сургуулийг өргөтгөн, багш нарын мэргэшил дээшлүүлэх, давтан сургах сургалтыг өргөтгөж,

чанарыг сайжруулах талаар Серб, Дани зэрэг улсын туршлага сонирхол татаж байна. Техник мэргэжлийн сургуулийн удирдлагыг бэхжүүлэх талаар удирдлагын шинэ арга барил нэвтрүүлэх, мэдээллийн технологийг хэрэглэх, сонирхогч талуудыг өргөн оролцуулах замаар засаглалын төгөлдөр механизм бий болгох, төвлөрлийг задлах зэрэг арга хэмжээг Хятад, Европ, Латин Америкийн улс орнуудад хэрэгжүүлж байна.

СУУРЬ, ХӨРВӨХ БА МЭРГЭШЛИЙН ЧАДВАР

Өнөөгийн ээдрээтэй, тодорхойгүй нөхцөл байдалд ямар төрлийн мэргэжлийн чадамж шаардагдах тухай олон улсын хэмжээнд идэвхтэй маргаан хэлэлцүүлэг өнөөдөр өрнөсөөр байна. Мэргэжлийн чадвар ба чадамжийн талаар олон янзын, ихэвчлэн ижил төстэй тодорхойлолтууд, тэдгээрийн ангиллын олон хувилбарууд нь төөрөгдөл бий болгож болох юм. Хэдийгээр чадвар, чадамж гэсэн хоёр нэр томъёог голдуу харилцан орлуулж хэрэглэдэг боловч энэ хоёр нэр томъёоны хооронд тодорхой ялгаа байдаг. Чадамж гэдэг ойлголт бол илүү өргөн хүрээтэй. Тодорхой орчин нөхцөлд болон тухайн шаардлагын дагуу мэдээлэл, аливаа зүйлийн тухай ойлголт, чадвар, үнэт зүйлс, хандлага зэргийг өргөн утгаар хамруулсан мэдлэгийг хэрэглэх чадварыг мэргэжлийн чадамж гэнэ. Залуу хүмүүст шаардагдах суурь, хөрвөх, техникийн болон мэргэжлийн гэсэн үндсэн гурван төрлийн чадварыг 2012 оны “Бүх нийтийн боловсролын хяналт, үнэлгээний дэлхийн тайлан”-д тодорхойлсон байна.

Хамгийн энгийн нь гэж болох суурь ур чадвар нь хүний өдөр тутмын хэрэгцээг хангахуйц ажил олоход зайлшгүй шаардлагатай бичиг үсгийн ба тоо бодох чадвар юм. Энэ суурь чадвар нь цаашид үргэлжлүүлэн боловсрол, мэргэжил эзэмшихэд болон хөрвөх чадвар ба техникийн болон мэргэжлийн чадвар олж авахад нь урьдчилсан нөхцөл болно.

Янз бүрийн ажлын байрны хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд хэрэглэж болох, ажил хайж олох, түүн дээрээ тогтож ажиллахад шаардлагатай өргөн хүрээтэй чадваруудыг хөрвөх чадвар гэнэ. Асуудлыг задлан шинжлэх, зохих шийдлийг олох, өөрийн санаа болон мэдээллийг оновчтой хүргэх, ажилдаа бүтээлч хандах, манлайлал ба ухамсартай байдлаа харуулах, энтерпренер авьяас чадвараа үзүүлэх зэргийг хөрвөх чадварт багтаана. Эдгээр чадвар нь боловсролын орчноос гадуур төлөвших тал бий. Гэхдээ тэдгээрийг нэмэлт боловсрол, давтан сургалтаар цаашид сайжруулж болно. Түүнээс гадна харилцааны соёл, цахим цагаан толгой, хамт олонтой багаар ажиллах зэрэг “дамжуулж болох чадвар”, “хорин нэгдүгээр зууны чадвар”, “когнитив бус чадвар” гэж янз бүрээр нэрлэгддэг ур чадварууд орно.

Олон төрлийн ажлын байр нь тусгай техник, мэргэжлийн мэдлэг чадвар шаардана. Тухайлбал, ур суулгах машин ашиглан ногоо тарих, тоосго өрөх, мужааны ажил хийх, эсвэл компьютер дээр ажиллах зэргийг дурдаж болно. Техникийн болон мэргэжлийн чадварыг дунд сургуульд суралцах явцдаа үйлдвэрлэлийн дадлага, хөдөлмөрийн хичээлийн хүрээнд, албан ёсны техник мэргэжлийн боловсрол олж авах замаар эсвэл дагалдан сурах уламжлалт арга, хөдөө аж ахуй дээр ажиллуулах зэрэг ажлын байр дахь сургалтаар олж авч болно.

“Зөөлөн”, “хөрвөх”, “когнитив бус”, “хорин нэгдүгээр зууны” зэрэг чадваруудыг төлөвшүүлэхэд анхаарлаа төвлөрүүлж байгаа нь боловсролын агуулга, арга зүйн талаарх өнөөгийн үзэл бодлыг баяжуулж байна.

БАРИМТ 1 - АНУ-ЫН БОЛОВСРОЛЫН ГУРАВДАХЬ ХУВЬСГАЛ

АНУ-д 1900 оны үеэс ахлах сургуулийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч үндэсний хэмжээнд бүх нийтийг хамарсан дунд сургуулийн системийг бий болгосон нь өөрчлөгдөж байгаа эдийн засгийн болон хувь хүний амьдралын хэрэгцээ шаардлагыг хангасан боловсролыг олгож чадсан ба америкийн боловсролын системийн өөрчлөлтийн анхны томоохон давалгаа байжээ. 1910 онд АНУ-ын залуучуудын дөнгөж 9%-нь ахлах сургуулийн дипломтай байсан бол 1935 онд 40 хувь нь ийм дипломтой болсон байна. Энэ хөдөлгөөний ач холбогдлыг Харвардын их сургуулийн эдийн засагч Клаудио Голдин "жинхэнэ хувьсгал" байсан гэж тэмдэглэжээ. Боловсролын системийн өргөжилт, тэлэлтийн хоёрдахь давалгаа нь 1960-аад оны үеэс бүх нийтэд коллежийн боловсрол олгох бодлогын үндсэн дээр хэрэгжсэн байна. 1965 онд АНУ-ын ерөнхийлөгч Линдон Жонсон дээд боловсролыг хөгжүүлэх хуулийг гаргаснаар дээд боловсролд олгох санхүүжилтийг эрс нэмэгдүүлсэн байна. Үүний үр дүнд муж улсууд 2 жилийн коллежийн хотхоныг байгуулж, багш бэлтгэдэг коллежиудын хөтөлбөрийг өргөжүүлэн мэргэжлийн бүх салбарыг хамруулсан байна. Үүний үр дүнд 1970 оноос 2016 оны хооронд дээд сургуулийн оюутны тоо 8.5 саяас 20.5 сая болтлоо хоёр дахин өссөн байна. Өнөөдөр боловсролын салбарын гуравдахь хувьсгал ирж байгааг эрдэмтэд, эдийн засагчид, ажил олгогчид анхааруулж байна. Охфордын их сургуулиас 2013 онд хийсэн судалгаагаар үл хөдлөх хөрөнгийн брокер, даатгалын ажилтан, зээлийн ажилтнууд зэрэг АНУ-д одоо байгаа ажлын байрны тал хувь нь ирэх 20 жилд компьютерийн системд шилжих эрсдэл байгааг тэмдэглэжээ. МакКинзи хүрээлэнгээс гаргасан тайланд 2030 он гэхэд америкийн ажилчдын гуравны нэг нь ажлаа солиход хүрнэ гэжээ. Хэрэв боловсролын салбарын эхний хоёр давалгааг боловсрол эзэмших хугацааг нэмэгдүүлэх замаар шийдэж, нийгмийн эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байсан бол 21-р зууны эдийн засагт ийм арга хангалтгүй болж байна. Харин хувь хүний амьдралын туршид сурч боловсрох, шинэ ур чадвар эзэмших нөхцлийг бүрдүүлэх явдал чухлаар тавигдах боллоо. Ажлаа хийх явцдаа шинэ мэдлэг, ур чадвар эзэмших боломжийг насан туршийн боловсролоор олгох нь америкийн боловсролын системд гарч байгаа гуравдахь хувьсгал юм. Урд өмнө нь зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажилгүй болсон, эсвэл ажлаасаа ямар нэг шалтгаанаар халагдсан зэрэг тохиолдолд давтан сургалтын талаар боддог байсан бол өнөөдөр өдөр тутам давтан сургалтын талаар хүн бүр бодох болж байна. Энэ бол өнөөдрийн бидний амьдралын жирийн үзэгдэл болох төлөвтэй байна.

БАРИМТ 2 - УЗБЕКИСТАН – УРАН ГАРТНУУДЫН ЭХ ОРОН

140 гаруй үндэстэн ястан оршин суудаг, 32 сая хүн амтай Узбекистан улс сүүлийн нэг жилийн дотор эерэг ардчилсан өөрчлөлтийг бүх салбарт эрчимтэй нэвтрүүлж, хөрш орнуудтайгаа хамтын ажиллагаагаа харилцан ойлголцол, эв нэгдлийн цоо шинэ шатанд гаргаж, олон улсын тавцан дээр өөрийн байр суурийг эзэмших зоригтой алхам хийж байна. Узбекистан улс Самарканд, Бухара, Хива, Шахрисябс зэрэг түүх соёлын 7000 гаруй объекттойн дээр 100000 гаруй эртний гар бичмэлийг хадгалж үлдээж чадсан баялаг түүхтэй улс юм. Тухайлбал, торго, атлас, хивс, хатгамал, керамик, алт мөнгөний болон төмрийн дархан, миниатур зургийн зэрэг чиглэлээр олон үе дамжсан уран гартнуудын эх орон ажээ. Керамикийн чиглэлээр Риштан гэдэг жижиг хот алдартай бөгөөд Ташкент хотноо дэлхийд нэрээ гаргасан 6 үеийн уран гартан эцэг Аквар, хүү Алишер Рахимов нар ЮНЕСКО-ийн тусламжтайгаар сургалтын төв байгуулан дунд сургуулийн сурагчдыг энэхүү ур чадвартаа сургаж байна. Япон, Герман, Англи, АНУ-ын мэргэжилтнүүд ирж тэдний ур чадварыг судалсан байна. Ферганы хөндийд байдаг Маргилон хот бол торго, атласны эх орон гэгддэг бөгөөд тэнд олон үе дамжсан уран гартнууд одоо хүртэл ур чадварыг өвлүүлэн ажиллаж байна. 2007 онд ЮНЕСКО-оос 9 үе дамжсан торго, атлас үйлдвэрлэгч Расул

Мирзаахмедовын удирдлагын дор сургалтын төв байгуулж ажиллуулсан байна. Энэ төвөөс торго, атлас, адрас зэрэг давуу нэхэх талаар сургалт явуулж, жил бүр Атлас Байрами гэдэг торгоны баярыг зохион байгуулдаг байна. 2017 оны 12 сард ЮНЕСКО-ийн биет бус өвийн хорооны хурлаар уг төвийг биет бус өвийг сурталчлах, үе дамжуулан хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж, хамгийн сайн туршлага гэж хүлээн зөвшөөрсөн байна. Укбекистанд төдийгүй дэлхийд өөрийн нэртэй брэндээ гаргаж чадсан хатгамалч эмэгтэй Мадина Касымбаева өөрийн ур чадвараа залуучуудад өвлүүлэх зорилгоор залуучуудыг дагалдуулан ажилладаг байна. Бухара хот бол алт мөнгө, төмрийн дархан урчуудаараа алдартай юм. Умуджон Алиев, Садык Муксинов зэрэг олон алдартай дархчуул өөрийн ур чадвараа үр хүүхдүүд болон залуу үеийнхэнд сургаж өвлүүлж байна.

ТЕХНИК, МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ОЛОН УЛСЫН III КОНГРЕССИЙН ЗӨВЛӨМЖ

ЮНЕСКО-оос 2012 оны 5 сарын 14-16-нд Шанхай хотод зохион байгуулсан “Техник, мэргэжлийн боловсролыг өөрчлөх нь: Ажил амьдралд шаардлагатай ур чадварыг бүрдүүлэх нь” гэсэн сэдэвтэй Техник, мэргэжлийн боловсролын олон улсын III конгрессоос мэргэжлийн ур чадвар олгох сургалтын талаар гишүүн орнуудад хандаж тодорхой зөвлөмж гаргасан байна.

1. Түргэн өөрчлөгдөж байгаа өнөөгийн нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн зах зээл ба техник, мэргэжлийн боловсролын хоорондын шүтэлцээг улам гүнзгийрүүлэхийн тулд одоо болон ирээдүйд шаардагдах ур чадварын хэрэгцээг зөв тодорхойлох, ажлын байрыг өөрчлөхөд хүчтэй нөлөө үзүүлж байгаа мэдээлэл холбооны технологийг сургалтанд бүрэн нэвтрүүлэх, өндөр ур чадвартай мэргэшлийн багш дутагдалтай мэргэжлүүдэд онцгой анхаарах, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн харгалзан үзэх, нарийн мэргэшлийн ур чадвар олгох сургалтын төлөвлөлт, чанарын үнэлгээг явуулахдаа холбогдох талуудыг өргөн оролцуулах механизмыг бий болгох нь зүйтэй гэж зөвлөжээ.

2. Ур чадварын сургалтын хүрээг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх талаар ур чадварын сургалтын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, асуудал шийдэх, асуудалд шүүмжлэлтэй хандах, ажил хэрэгч хандлага зэрэг хөрвөх ур чадварыг эзэмшүүлэхэд онцгой анхаарч суралцагчдыг амьдралд бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон нийгмийн эмзэг давхаргын иргэдэд мэргэшлийн ур чадвар олгох талаар шинэ арга барил хэрэгжүүлэхийн чухлыг онцгойлон зөвлөжээ.

3. Мэргэжлийн ур чадварыг хүлээн зөвшөөрч, хувь хүний мэдлэг чадвар эзэмших арга замыг уян хатан болгож, олж авсан ур чадварыг бодьтой, үнэн зөв үнэлж, үндэсний төдийгүй олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх боломжийг олгох, ур чадварын боловсролыг ерөнхий боловсролын системтэй уялдуулан, цаашдаа дээд боловсрол олж авах замыг тодорхой болгох, ажил дээрээ өсөж албан тушаал дэвших боломжийг бүх талаар тухайлбал, зах зээлийн мэдээллээр хангах, хувь хүний сонирхол авьяас чадварыг илрүүлэх, удирдах ажлын мэдлэг чадвар туршлага эзэмших зэрэг боломжоор хангаж байхыг зөвлөсөн байна.

4 Түүнээс гадна техник, мэргэжлийн боловсролын талаар судалгаа хийх, сайн үр өгөөжтэй туршлагын талаар мэдээлэл цуглуулах, төрийн бодлогын үр өгөөжийг дээшлүүлэхэд тус болохуйц шинжлэх ухааны үндэстэй, бодит баримтад тулгуурласан зөвлөмж гаргах, ажил олгогчид, ажилчид, иргэний нийгэм, залуучууд суралцагчдыг хамарсан удирдлага, хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүдийг дэмжих, мэргэжлийн ур чадвар олгох сургалтыг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг олшруулах, ур чадварын сургалт бол боловсролд оруулсан үр өгөөжтэй хөрөнгө оруулалт болох талаар өргөн сурталчлан тайлбарлах зэрэг олон зөвлөмжийг гаргажээ.

БАРИМТ 3 - УР ЧАДВАРЫН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Дэлхийн II дайны дараа Испанид ур чадварлаг ажилчдын хэрэгцээ маш ихээр шаардагдаж байсан бөгөөд Испаний Залуучуудын холбооны ерөнхий захирал Хосе Антонио Элола Оласо ур чадвартай ажилчдыг бэлтгэх, үүнд залуучууд эцэг эхчүүдийн сонирхлыг татах үүднээс 1947 онд үндэсний ур чадварын тэмцээн зохион байгуулсанд 4000 хүн арав гаруй мэргэжлээр оролцож ур чадвараа сорьсон байна. Үүний дараа 1950 онд Техник, мэргэжлийн олон улсын байгууллагыг байгуулж, 1990 оноос Дэлхийн ур чадварын байгуулага болгон өөрчилсөн байна. Дэлхийн ур чадварын байгууллагад манай улс 2015 онд элсэн орж тэмцээнд оролцох эрхээ авчээ. Манай баг сүүлийн 2 удаагийн тэмцээнд оролцсон байна. 2017 оны 10 сард Арабын Нэгдсэн Эмират улсын Абу Даби хотноо болсон Ур чадварын 44 дэх удаагийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд 77 гишүүн орны 1300 оролцогч, 51 төрлөөр өрсөлдөж, манай улсаас оролцогч гагнуурын төрөлд тусгай шагнал хүртсэн байна. Манайхан гагнуурчин, үсчин, тоосго өрөлт, тогооч, гоо сайхан, мужаан, токарь, хавтанцар наагч, сантехник, цахилгаан зэрэг мэргэжлээр дээрх тэмцээнүүдэд оролцсон байна. Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Дэлхийн ур чадварын байгууллагад гишүүнээр элсэх, үндэсний хэмжээнд ур чадварын тэмцээн зохион байгуулах тал дээр идэвх санаачлага гаргаж ажиллаж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Олон улсын тэмцээнд оролцох асуудлыг цаашид өргөн сурталчилж, суралцагчдын урам зоригийг сэргээж, сурах хүсэл эрмэлзлэлийг тал бүрээр дэмжих нь хувь хүний хөгжилд ихээхэн хувь нэмэртэйн дээр манай орны эдийн засагт өндөр мэргэшил эзэмшсэн, нарийн ур чадвартай ажилчдыг бэлтгэхэд чухал ач холбогдолтой учраас энэ санаачлагыг бүх талаар дэмжихэд ажил эрхлэгчдийг татан оролцуулах, төрийн бодлогоор дэмжих хэрэгтэй.

МАНАЙД УР ЧАДВАРЫН СУРГАЛТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ӨГӨХ ЗӨВЛӨМЖҮҮД

1 Засгийн газрын 2016 оны 06 дугаар сарын 06 өдрийн 304 тоот тогтоолоор баталсан “Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т энэ салбарын нэр хүндийг өсгөх зорилтыг тэргүүн зэрэгт тавьжээ. Ер нь манай ард түмний дунд ТМС-ийн талаарх ойлголтыг өөрчлөх талаар дорвитой арга хэмжээ авах цаг болжээ. ТМС, МСҮТ, Политехник коллеж гэх мэтээр олон янзаар нэрлэж байгаа ч байдал эрс өөрчлөгдөж чадахгүй байна. Ийм учраас эдгээр сургуулиудыг ур чадварын сургууль болгон өөрчилж, 2 жилийн коллежийн статус өгч, сургалтын чанарыг эрс дээшлүүлж, дунд сургууль болон их сургуультай уялдаа холбоог тухайлбал, коллежид үзсэн хичээлүүдийн кредит цагийг их сургуулиуд хүлээн зөвшөөрдөг болгох зэргээр нийтэд ойлгомжтой ил тод болгож, ажил эрхлэгчдээс өндөр ур чадвартай нарийн мэргэшлийн ажилчдын цалин урамшууллыг өсгөж, суралцагчдын сонирхол, авьяас чадварыг хөхүүлэн дэмжвэл зохино.

2 Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлыг Боловсролын яамнаас салгасан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хийгдсэн боловч сургалтын төлөвлөгөө, арга зүй, багш бэлтгэх зэрэг олон чиглэлээр боловсролын тогтолцооноос хөндийрүүлж, боловсролын нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд тус болох нь бага байна. Нөгөө талаас, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэр хүнд олон нийтийн дунд өөрчлөгдөж чадаагүй, дунд сургууль, дээд боловсролын системтэй уялдаа холбоо сул байгаа зэрэг нь нийгмийн сэтгэлгээнд дорвитой эерэг сэтгэгдэл төрүүлж, тэднээс дэмжлэг авч чадахгүй байна. Ийм учраас энэ тогтолцоог эргэн харах шаардлагатай байна.

3 Техник, мэргэжлийн сургуулийг нарийн мэргэшлийн ур чадвар олгох сургууль болгохоор өөрчлөн шинэчилж, бэлтгэж байгаа мэргэшлийн чиглэлийг улс орны эдийн засгийн хэрэгцээ шаардлагын дагуу тогтмол уян хатан өөрчилж, ерөнхий боловсролын дунд сургууль болон их дээд сургуультай уялдаа холбоог бэхжүүлэх хэрэгтэй.

4 Нарийн мэргэшлийн ур чадварыг богино хугацааны сургалтаар олгох, насанд хүргэгчдэд тодорхой мэргэшлийн ур чадвар олгож, зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, ахуйн болон аж ьдралын тустай чадавхийг зааж сургах нээлттэй онлайн сургалт бий болгох, насан туршдаа ур чадвараа дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх, “ хоёрдахь боломж” олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч, эрх зүйн үндсийг бий болгож, бүх нийтийн санаачлагыг өрнүүлбэл зохино.

5 Нарийн мэргэшлийн ур чадварыг дотооддоо төдийгүй, гадаадад хүлээн зөвшөөрүүлэх талаар олон улсын гэрээ хэлэлцээ хийх, хамтарсан сургалт явуулах, олон улсын уралдаан тэмцээнд тогтмол оролцох, гадаадын залуучуудад монгол орны өвөрмөц онцлог бүхий мэргэжлээр ур чадвар олгох сургалт явуулах ажлыг эхлүүлбэл зохино.

6 Ур чадварын сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд өндөр мэргэшлийн багш нарыг сургах үйл хэрэгт татан оролцуулах, тэднийг түшиглэн сургалтын төв байгуулах, ялангуяа үндэсний гар урлалын чиглэлийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын төвүүдийг олноор байгуулж ажиллуулах шаардлагатай. Мөн их дээд сургуулиудад мэргэшлийн сургуулиудын багш бэлтгэх, давтан бэлтгэх хөтөлбөрийг системтэй хэрэгжүүлж, нарийн ур чадвар эзэмшсэн багш бэлтгэн нийлүүлэх ажлыг зохион байгуулбал зохино.

7 Дээд боловсрол эзэмшиж байгаа залуучуудад мэргэжлийн чиглэлээр болон хоёрдахь мэргэшлийн ур чадвар олгох сургалтыг олгох талаар дорвитой санаачлага гаргаж ажиллахыг их дээд сургуулийн удирдлагуудад уриалж байна.

8 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачлан боловсруулсан мэргэшлийн үндэсний хүрээг үндэслэн бүх шатны сургуулийг хамарсан мэргэшлийн үндэсний хүрээг тодорхойлж, улмаар мэргэжил боловсролыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах улсын хэмжээний нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй.

ХОЛБОГДОХ ЭХ СУРВАЛЖУУД

Allais, S. 2010. The Implementation and Impact of National Qualifications Frameworks: Report of a Study in 16 countries. Geneva, Skills and Employability Department, ILO.

Adalet McGowan, M. and D. Andrews (2015), "Labour market mismatch and labour productivity: Evidence from PIAAC data", OECD Economics Department Working Papers, No. 1209, OECD Publishing, Paris.

CEDEFOP and European Commission. 2010. European inventory on validation of non-formal and informal learning.

Facer, K. 2011. Learning Futures: Education, Technology and Social Challenges. New York, Routledge.

Fien, J. 2013. Education for sustainable development in technical and vocational education and workplace training. Background paper prepared for Decade for Education for Sustainable Development Final Report.

OECD (2016), "Overview: Why skills matter", in Skills Matter: Further Results from the Survey of Adult Skills,
OECD Publishing, Paris.

UNESCO, 2012. Youth and Skills: Putting education to work. EFA Global Monitoring Report 2012. Paris, UNESCO.

SUMMARY

The intensification of economic globalization is producing patterns of low-employment growth, rising youth unemployment and vulnerable employment. The fact that appropriate jobs are becoming scarcer is causing increasing frustration among families and young graduates around the worldTechnical and vocational education and training (TVET) is steadily emerging as a winner in the 'race to the top' of global debates and government priorities for education and national development agendas. In many countries, the public in general do not favour TVET, and a significant number still regard TVET as second best or even a choice of last resort. Young people are beginning to question the 'return on investment' of traditional 'high status' educational routes. Although this negative perception is slowly changing, and it does vary within the population and between different forms of TVET, many individuals and families still find some forms of TVET unattractive relative to general secondary education and academic tertiary education programmes. Policy measures have been introduced to improve the alignment of skills development with labour market demands include: i) better identification and anticipation of labour market skills needs, ii) measures for closing skills gaps, iii) improving youth employability, iv) meeting the skills requirements of the informal sector, v) meeting the skills demands of the rural economy, and vi) providing an appropriate mix of broader competencies alongside specialist skills. The efforts to strengthen the capacity of the TVET to respond to the demands of economic growth, social equity, or the sustainability of development include: i) expanding and diversifying access; ii) expanding work-based learning and cooperation with businesses; iii) enhancing quality and relevance; iv) professionalizing TVET teachers and trainers; v) empowering learners; vi) strengthening the management of TVET institutions; vii) improving governance and stakeholder participation; viii) developing supporting frameworks for implementation; and ix) using funding to steer TVET. A number of responses have been proposed to address this disconnection between formal education and training and the world of work, including retraining of workers, second chance programmes and stronger partnerships with industry. The EFA Global Monitoring Report 2012 proposes a useful approach to different types of skills in relation to the world of work. It identifies three main types of skills that all young people need: foundation, transferable, and technical and vocational skills. This policy brief explores how to reform the vocational education system into the skill development stage of the education system of the country.

ШУТИС-ИЙН ОЛОН УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ТӨВ

Түс төв энэ хичээлийн жилээс сар бүр дээд боловсролын тулгамдсан асуудлаар "Дээд боловсролын бодлогын өөрчлөлт" цувралыг хэвлэж гарган, мөн ШУТИС-ийн веб хуудсаар түгээх болно. Эдгээр цуврал нь дээд боловсролын бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачдад зориулагдсан бөгөөд энэ цувралын материалыг ашиглах, өөрсдийн судалгаанд ишлэл татан хэрэглэхийг бүрэн дэмжиж, Creative Commons нээлттэй лицензээр зохиогчийн эрхээ баталгаажуулсан.

Судалгааны баг
Доктор, профессор Д.Бадарч
Доктор, профессор Б.Очирбат
Доктор, дэд профессор Т.Намнан
Судлаач Б.Мөнххүж
Хянан тохиолдуулсан: Б.Очирбат

CC BY